



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/15

Жаргалтхаан сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 03 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүн амыг стандартын шаардлага хангасан эрүүл хүнсээр хангах, сумын брэнд бүтээгдэхүүнийг шинээр бий болгох, орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэгчдийн хөдөлмөрийг үнэлж, сурталчлах зорилгоор зохион байгуулах “Цагаан сар- Цагаан идээ 2026” үзэсгэлэн худалдааг зохион байгуулахад зориулж 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөгийг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан, Эко жаргалтхаан хөтөлбөрийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Т.Энхсайхан нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.ГАНБАТ